



110

БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/60

Номгон

Нохой, муурын устгалын ажил
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлын 2015 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Баянхонгор сумын нутаг дэвсгэрт гэрийн тэжээвэр амьтдыг тэжээх, арчлах, хураамж тогтоох, золбин нохой, муур устгах журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор гэр хороолол болон орон сууц, нийтийн эзэмшил талбайн золбин нохой, муурны устгал хийх ажлыг 2023 оны 03 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд зохион байгуулж явуулсугай.

2.Золбин нохой, муурны устгалын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийг ахлагч

С.Батцэрэн

(Засаг даргын Орлогч)

Гишүүдэд:

Ц.Баясгалан

(“Цэвэр хот” ОНӨААТҮ Газрын дарга)

(Багийн Засаг дарга нар)

(Багийн Хэсгийн байцаагч, Цагдаа, Олон

нийтийн цагдаа нар)

(Сумын Байгаль орчны алба)



(Мал эмнэлгийн алба (Ариутгал)

3.Нохой, муурны устгал хийхэд болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, Цагдаагийн дэд хурандаа Б.Мөнгөнтулга, багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4.Нохой, муурны устгал хийх ажлын сэрэмжлүүлэг мэдээллийг иргэд, олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажилд хариуцлагатай хандаж ажиллахыг Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан ажилтан (Д.Отгонтунгалаг)-д үүрэг болгосугай.

5.Нохой, муурны устгалын ажлын үр дүн, тайлан болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (С.Батцэрэн)-д үүрэг болгосугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Хүрэлсүх)-д даалгасугай.

ДАРГА   Г.ЭНХБАЯР